



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/579

Алтай хот

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай” 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны “Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай” 211 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Есөнбулаг сумын Наран багийн нутаг дэвсгэрт хэрэгжиж буй “Хан-Алтай” төслийн алтны үндсэн ордын исэлдсэн хүдрийг боловсруулах зориулалттай “Нуруулдан уусгах байгууламж, “Хүдэр боловсруулах үйлдвэр”, 0.4/10 кВА-ын 2х2500 кВт хүчин чадалтай дэд станц, хуваарилах байгууламж болон ЦДАШ-ын холболтын ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Б.Бямбадорж	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)
Гишүүдэд:	М.Мандаххүү	(Архивын тасгийн дарга)
	Ц.Амарсанаа	(Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, хошууч)
	Б.Батбилэг	(Мэргэжлийн хяналтын газрын барилгын техникийн хяналтын улсын байцаагч)
	Д.Отгонжаргал	(Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын улсын байцаагч)
	М.Мөнхцэцэг	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын инженерийн барилга байгууламж хариуцсан мэргэжилтэн)
	Б.Бээжин	(“Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн үйлдвэрлэл эрхэлсэн дэд захирал бөгөөд ерөнхий инженер)

2.

А.Лхагвадэлгэр ("Хан-Алтай ресурс" ХХК-ийн төслийн захирал)
(Зохиогчийн төлөөлөл)
(Гүйцэтгэгчийн төлөөлөл)

Нарийн бичгийн дарга: М.Мөнх-Эрдэнэ ("Хан-Алтай ресурс" ХХК-ийн Эрүүл мэнд аюулгүй ажиллагаа, байгаль орчин нутаг зөвшөөрлийн ерөнхий менежер)

2.Барилга, инженерийн байгууламжийн угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, зураг төсөл, бусад холбогдох баримт бичгийн бүрдэлтэй нийцүүлэн хүлээн авч, үр дүнг 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор танилцуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



Г. ЧИНБАТ